



Г

СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

Г

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.09.27 № 03/1890
танай _____ -ны № _____ -т

Г Тодруулга хүргүүлэх тухай Г

Тус газраас 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр зарласан Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх БОАЖЯ/20240101067 дугаартай Улсын болон орон нутгийн өмчит байгууллагын усан халаалтын зууханд техникийн шинэчлэлт хийх ажлын захиалагчийн хяналт тавих байгууллагаас техникийн тодорхойлолт ирүүлсэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь заалтын дагуу Тендер шалгаруулалтын баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн "ТЭЗҮ" хэсэгт байгаа 8-н байршлын ажлын даалгавруудыг эргүүлэн татаж тодруулгаар техникийн тодорхойлолтыг хүргүүлж байна.

Өмнөх 8-н байршлаас Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн байршил хасагдаж, шинээр Хан-Уул дүүргийн 135 дугаар сургууль, 219 дүгээр цэцэрлэг болон Баянзүрх дүүргийн 132 дугаар сургууль, 212 дугаар цэцэрлэг гэсэн 2 байршил нэмэгдсэнийг анхаарна уу.

№	Тендер шалгаруулалтын баримт бичгийн заалт	Орсон өөрчлөлт
1	Тендер шалгаруулалтын баримт бичиг дэх өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2 дахь заалт: 2. Нийт ажлын төсвийг ажлын зураг төсөл боловсруулах, тоног төхөөрөмж угсралт ажлын даалгаврын дагуу тооцож эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулж ирүүлнэ. (Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй хууль, тогтоомж, журам, зааврын дагуу төсөв зохиох программаар гүйцэтгэнэ.) гэснийг;	2. Нийт ажлын төсвийг техникийн тодорхойлолтын дагуу тооцож эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулж ирүүлнэ. (Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй хууль, тогтоомж, журам, зааврын дагуу төсөв зохиох программаар гүйцэтгэнэ. гэж;

	<p>2 Тендер шалгаруулалтын баримт бичиг дэх өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2 дахь заалт:</p> <p>6.Ажлын даалгаварт заасан нийт 8-н байршилтай нэг бүрчлэн танилцаж, тэмдэглэл үйлдэж, фото зургийн хамт өөрийн тендерт ирүүлнэ. гэснийг;</p>	<p>6.Ажлын даалгаварт заасан нийт 9-н байршилтай нэг бүрчлэн танилцаж, тэмдэглэл үйлдэж, фото зургийн хамт өөрийн тендерт ирүүлнэ. гэж;</p>
	<p>3 Тендер шалгаруулалтын баримт бичиг дэх өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1 дэх заалт:</p> <p>3.Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага. “Шаардана” Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй (Хий, цахилгаан хосолсон халаалтын зуух угсралт) ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байна. гэснийг;</p>	<p>3.Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага. “Шаардана” Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй (Шаардсан тусгай зөвшөөрлийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил) ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байна. гэж;</p>

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.

Хавсралт 8 хуудастай.



Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар

Удирдлага

Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Даваадорж Батцэцэг

2024.09.27 15:51



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ
ТЭМЦЭХ ГАЗАР**

Наадамчдын зам 1200, Арцатын ам, 4 дүгээр хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100
Утас/Факс: (976-11) 31 48 76
Цахим шуудан : info@aprd.ub.gov.mn
Цахим хуудас: www.aprd.ub.gov.mn

2024.09.26 № 01/398
танай _____ -ны № _____ -т

Г Хамтран ажиллах тухай Г

Танай газраас 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Худалдан авах ажиллагааны цахим систем ([tender.gov.mn](#))-ээр зарласан БОАЖЯ/20240101067 дугаартай “Улсын болон орон нутгийн өмчтэй байгууллагын усан халаалтын зууханд техникийн шинэчлэлт хийх ажил”-д захиалагчийн хяналт тавьж ажиллаж байна.

Уг ажлын хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр ирүүлсэн 4/819 тоот албан бичгийн дагуу тус газрыг хасаж Хан-Уул дүүргийн 135 дугаар сургууль, 219 дүгээр цэцэрлэг болон Баянзүрх дүүргийн 132 дугаар сургууль, 212 дугаар цэцэрлэгийг оруулан техникийн тодорхойлолтыг шинэчлээд байна.

Иймд өмнөх ажлын даалгавруудыг эргүүлэн татаж шинэчлэгдсэн техникийн тодорхойлолтын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж өгнө үү.

1 дүгээр хавсралт: Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс ирүүлсэн бичиг, 2 хуудастай.

2 дугаар хавсралт: Шинэчилсэн техникийн тодорхойлолт, 3 хуудастай.



Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар

Удирдлага

Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Ган-Очир Даваажаргал

2024.09.26 08:45



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАРТ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

IX хороо, Шархад, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13320
Утас: (976-11) 45 82 98, Цахим шуудан: ncmh@ncmh.gov.mn,
Цахим хуудас: www.ncmh.gov.mn

2024.09.18 № 4/819

танай _____ -ны № _____ -т

Г

Хүсэлт хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн яамны харьяа Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь 1929 онд байгуулагдсан сэтгэцийн эрүүл мэндийн төрөлжсөн мэргэжлийн тусlamж үйлчилгээг үндэсний хэмжээнд үзүүлдэг, сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулиар зохицуулагдан ажилладаг улсын хэмжээний лавлагаа төв эмнэлэг ю.

Өнөөдрийн байдлаар тус төв нь 550 хэвтүүлэн эмчлэх ортой, 505 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтантайгаар сэтгэцийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг Монголын хүн амд үзүүлж байна.

Манай үндэсний төв нь төвлөрсөн дулааны шугамд холбогдоогүй, 1961 оноос одоог хүртэл өөрийн дэд бүтэцтэй, уурын зуухаар халаалтаа шийдсэн 6 объект барилгатай, Улаанбаатар хотын цорын ганц томоохон эмнэлгийн байгууллага юм.

Засгийн газрын 2018 оны "Улаанбаатар хотод түүхий нүүрсийг хориглох тухай" 62 дугаар тогтоолыг үндэслэн 2024 оны 09 дүгээр сараас эхлэн ангилсан нүүрсийг хориглож мидлингээр солих шийдвэр гарваад байна. Мидлинг түлшинд тохируулж тоног төхөөрөмж солих, шинэ халаалтын зуухны тооцоолол, судалгааг хийх, халаалтын зуухны өөрчлөлт сайжруулалт хийх шаардлага үүсээд байна.

Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар хамтран хийн халаалтын зуух сууринуулах 650 сая төгрөгийн санхүүжилтийг шийдсэн. Тус төвийн Удирдлагын зөвлөл нь 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн хурлаар хэлэлцэж дараах шийдвэрийг гарваад байна. Үүнд:

1. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ашиглагдаж буй талбай 65448 м², хэвтүүлэн эмчлэх 6 объект барилгатай, хэрэгцээт дулаан: 1.2 Гкал/м³, байрны халаалт 0.8 Гкал/м³, хэрэгцээний халуун ус 0.4 Гкал/м³, салхивч 0.00 Гкал/м³ байгаа тул шинээр тавих хийн зуухны халаах хүчин чадал бүх объектыг халааж хүрэлцэхгүй.

2. Өвлүйн улирал эхэлж гадаа хүйтэрч байгаа тул уг ажлыг хийх боломжгүй нөхцөл үүссэн.

3. Шинээр тавигдах хийн халаалт нь манай төвийн нийт 5 объектийг халааж чадахгүй зөвхөн нэг барилгыг сонгож дулаан халаалтын асуудлыг шийдвэрлэх хүчин чадалтай гэж мэдээлж байгаа тул дараа жилийн хавраас бэлтгэл ажлыг хангаж, иж бүрэн технологийн шийдэл гаргах шаардлага үүссэн.

4. Хийн халаалтын систем нь ашиглалтын зардал ихтэй, одоогоор манай эмнэлгийн төсөвт уг зардал суугаагүй, санхүүжилт байхгүй, Эрүүл мэндийн яамнаас дэмжлэг үзүүлэх боломжгүй гэсэн хариу ирсэн.

5. Хийн халаалтын зуухыг ажиллуулах хүний нөөц, мэргэжилтэн байхгүй, хэрэглэж байсан туршлагагүй, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдэх магадлалтай.

Иймд Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулагдах хийн халаалтын зуух суурилуулах тендер шалгаруулалтын баримт бичгээс манай үндэсний төвийн нэрийг хасаж өгнө үү.



БАТЛАВ
ХЭСЭГЧИЛСЭН
ХАНГАМЖИЙН УДИРДАХ ГАЗАР
ОНӨААТУГ-ЫН ДАРГА

Г.БАТТУЛГА ·

2024...оны...09...сарын...20...

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.	Ажлын үндэслэл	Агаарын чанарыг сайжруулах бүсэд байрладаг, дулаан хангамжийн төвлөрсөн системд холбогдох боломжгүй улсын болон орон нутгийн өмчтэй байгууллагуудын усан халаалтын зууханд техникийн шинэчлэл хийх			
		Агаарын чанарыг сайжруулах бүсэд байрладаг улсын болон орон нутгийн өмчтэй байгууллагын усан халаалтын зууханд хийн болон цахилгаан зуух сууринуулах, техникийн шинэчлэл хийх, зураг төсөв зохиох, тоног төхөөрөмж, нийлүүлж угсралт			
2	Байгууламжийн байршил, зориулалт, хүчин чадал /бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл/	Агаарын чанарыг сайжруулах бүсэд байрладаг улсын болон орон нутгийн өмчтэй байгууллагын усан халаалтын зууханд хийн болон цахилгаан зуух сууринуулах, техникийн шинэчлэл хийх, зураг төсөв зохиох, тоног төхөөрөмж, нийлүүлж угсралт			
		Нэрс	Хордоо	Дулааны ачаалал /кВт/	Теслээр гүйцэтгэх ажил, шаардлага
		1 БЗД 79-2 -р сургууль	10	338	Хийн болон цахилгаан хосолмол ажиллагаатай зуух сууринуулах, 1 дүгээр хэлхээ шинэчлэх, Зуухны болон баллоны байр барих, "Хийн хангамж БНБД 42-01-21, хийн хангамжийн угсралт БНБД 42-02-04
		2 ЧД 117-р сургууль	19	595,7	Хийн болон цахилгаан хосолмол ажиллагаатай зуух сууринуулах, 1 дүгээр хэлхээ шинэчлэх, Зуухны болон баллоны байр барих, "Хийн хангамж БНБД 42-01-21, хийн хангамжийн угсралт БНБД 42-02-04
		3 ЧД 83-р цэцэрлэг	15	633,5	Хийн болон цахилгаан хосолмол ажиллагаатай зуух сууринуулах, 1 дүгээр хэлхээ шинэчлэх, Зуухны болон баллоны байр тусгаарлах, "Хийн хангамж БНБД 42-01-21, хийн хангамжийн угсралт БНБД 42-02-04
		4 ХҮД Буянт ухаа цэвэрлэх байгууламж	10	327	Хийн болон цахилгаан хосолмол ажиллагаатай зуух сууринуулах, 1 дүгээр хэлхээ шинэчлэх, Зуухны болон баллоны байр тусгаарлах, "Хийн хангамж БНБД 42-01-21 хийн хангамжийн угсралт БНБД 42-02-04,
		5 СХД 122-р сургууль /өргөтгөлийн барилга/	22	983	Хийн зуух сууринуулах, 1 дүгээр хэлхээ шинэчлэх, Зуухны болон баллоны байр барих, "Хийн хангамж БНБД 42-01-21, хийн хангамжийн угсралт БНБД 42-02-04
		6 СХД 143-р сургууль	23	1002	Төвлөрсөн дулаанд холбох зураг, төсөв зохиох
		7 ХҮД, 135-р сургууль, 219-р цэцэрлэг,	10	989,3	Хийн зуух сууринуулах, 1 дүгээр хэлхээ шинэчлэх, баллоны байр барих, "Хийн хангамж БНБД 42-01-21 хийн хангамжийн угсралт БНБД 42-02-04,
		8 БЗД, 132-р сургууль, 212-р цэцэрлэг	27	887,5	Хийн зуух сууринуулах, 1 дүгээр хэлхээ шинэчлэх, баллоны байр барих, "Хийн хангамж БНБД 42-01-21, хийн хангамжийн угсралт БНБД 42-02-04

		9	НДүүрэг.. Чандмань налайх ОНӨААТҮГ-ЫН	5		Халаалтын зууханд тоног төхөөрөмж нийлүүлж угсрах. - LB6B редуктор 1,1 кВт 5 ш - TPE 100-650/2 NC-A3-F-O-DAQF-UW1 Сүлжээний насос 55 кВт Ф200 ган шугам 60 метр Ф200 ган хаалт 10 ширхэг
3	Технологийн шийдэл, дэвшилтэт, хаягдапгүй технологи талаар		Аюулгүй ажиллагаа, чанарын шаардлага хангасан тухай баталгааны сертификаттай, олон улсын зах зээлд өргөн нэвтэрсэн усан халаалтын системд ажиллах зориулалттай хийн болон цахилгаан зуух дагалдах тоноглолын хамт сууринуулах.			
4	Ашиглалтын ажиллагаа	горим,	Хийн зуух болон цахилгаан зуухны тоног төхөөрөмж нь эрчим хүчиний хэмнэлттэй халаалтын улирлын (8 сар) турш тасралтгүй ажиллана. Хийн болон цахилгаан зуухны хүчин чадлыг сонгоходоо тухайн барилтын хала02-04алтын тооцоот ачааллыг өсгесэн ачааллаар тооцоолж сууринуулах. Сургууль, цэцэрлэг тус бүрд Монгол орны эрс тэс уур амьсгалд таарах олон улсын стандарт шаардлага хангасан эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан, хийн болон цахилгаан тоолуур сууринуулах. Гэмтэл saat ал, осол аваарын үед дулааны системийн бүрэн ачааллыг хангах цахилгааны нөөц үүсгүүр бүхий зөөврийн генератор сууринуулах;			
5	Ажлын бүрэлдэхүүн					<p>1. Хийн болон цахилгаан зуухны дагалдах тоноглолын холболтын схем боловсруулах. Энэхүү схемийг мэргэжлийн зөвлөх инженерээр хянуулсан байх; Хийн болон цахилгаан зуухны дагалдах тоноглолын сонголтын тооцоо хийх;</p> <p>2. Халаалтын системийн 1-р хэлхээ буюу хийн болон цахилгаан зуухны халаах ажлын бие нь ус байгаа тохиолдолд эрчим хүчиний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэмд заасан усны pH-ийн норм хэмжээг хангах зориулалт бүхий нэмэлт ус боловсруулах тоноглол сууринуулна.</p> <p>3. Барилгын дулааны тооцоот ачаалал болон гадна агаарын температур -39 градус цельсийн байх үед барилгын халаах хэрэгсэлд өгөх усны температурыг +95 градус цельсийн, буцах усны температурын +70 градус цельсийн байхаар тооцож тоноглолын хүчин чадлыг сонгоно.</p> <p>4. Тоног төхөөрөмжийн угсралт, сууринуулалт тэдгээрийг холбосон хийн болон усны шугам хоолойнуудын монтаж угсралтын ажлууд дээр гүйцэтгэлийн зураг гаргаж эрх бүхий байгууллагаар магадлал хийлгэж захиалагч, ашиглагч байгууллагуудад хүлээлгэн өгнө.</p> <p>5. Хий хадгалах болон цахилгааны хуваарилах байгууламжийн тооцоо хийх;</p> <p>6. Хийн болон цахилгаан зуух ба холбогдох тоноглолуудыг угсрах ажлын зураг гаргах, мэргэжийн зөвлөх инженерээр хянуулах;</p> <p>7. Ажиллаж буй халаалтын системийн бодит байдлыг судалж угсралтын ажлын бэлтгэл хангах;</p> <p>8. Халаалтын нүүрсний зуухны байранд хийн болон цахилгаан зуух, холбогдох тоноглол байрлуулах;</p> <p>9. Барилга шинээр барих. Барилгын дулаан хамгаалалтын төлөвлөлт БД 23-103-10</p> <p>10. Хий хадгалах байгууламжаас зуухны байр руу хийн шугам хоолой татах, бэхлэх, сууринуулах;</p> <p>11. Хийн болон цахилгаан зуухны удирдлагын самбарыг байрлуулж доторх хэрэгслүүдийг тэжээлийн кабелтай холбох;</p> <p>12. Хийн халаалтын зуухны усан талын холболтын схемийг гаргаж насос, хаалтууд ба тэлэх савны ажиллагаа хэвийн эсэхийг шалгаж шаардлага хангахгүй бол шинээр сууринуулах;</p>

		<p>13. Бүрэн холболт хийсний дараа турших, тохиргоо хийх;</p> <p>14. Дэд өртөөний 0,4 кв талын ерөнхий оруулгад СХЗҮТ загварын туршилтад орсон DLMS протоколыг дэмждэг 3 фазын баталгаат бүрэн электрон тоолуур, ачаалалд тохирсон гүйдлийн трансформаторыг тусгай хайрцагт суурилуулах.</p> <p>15. Шугам дэд өртөөний "Ажлын зураг төсөл"-ийг тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцэн, мэдээллийн санд оруулсан байх, систем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.</p>
6	Зураг төслийн бурдэл,	<p>Гүйцэтгэгч байгууллага хийн зуух болон тоног төхөөрөмжийн байрлалын зураг, техникийн иж бүрэн баримт, бичгийг ажил дууссаны дараа захиалагч болон ашиглагч талд хүлээлгэж егөх. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах зөвшилцөх, магадлал хийх болон бусад БНБД, БД холбогдох стандартыг мөрдлөг болгох.</p>
7	Гүйцэтгэгч байгууллагад тавигдах шаардлага	<p>Гадаадын ба дотоодын зах зээлд өргөн нэвтэрсэн хийн болон цахилгаан зуухны талаар судалгаатай, богино хугацаанд нийлүүлэх санхүүгийн чадвартай байх;</p>
8	Тусгай шаардлага ба нөхцөл	<p>Ерөнхий шаардлага:</p> <p>Хийн болон цахилгаан зуухны иж бүрдэл нь дараах шаардлагыг хангасан байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Гадаадын болон дотоодын зах зээлд өргөн нэвтэрсэн. 2. Аюулгүй ажиллагаа, чанаарын шаардлага хангасан тухай баталгааны сертификаттай, барилга байгууламжийн галын аюулгүй байдал БНБД 20-01-02. 3. Тухайн газар суурилуулах хийн болон цахилгаан зуухны нийлбэр чадал нь ажлын даалгаварт заасан утгаас бага байж болохгүй бөгөөд түүнийг үйлдвэрлэсэн газрын техникийн тодорхойлолтыг үндэслэн магадална. 4. Хийн болон цахилгаан зуухны чадлыг нь шатлан тохируулах автомат болон гар удирдлагатай байх. 5. Хийн болон цахилгаан зуухны аюулгүй ажиллагаа нэн чухал бөгөөд халаалтын системийн усны хаалтууд санамсаргүй байдлаар хаагдсан, эсвэл усан систем бөглөрсөн үед зуух ажиллавал усны даралт ба температур огцом нэмэгдэж улмаар дэлбэрэх аюул гарахаас хамгаалахын тулд усны даралтын хэт өсөлтийн давхар хамгаалах хэрэгсэл, тухайлбал аваарын механик клапан, мөн хийн зуухны таслах температурын болон даралтын релетэй байх. 6. Усан болон цахилгаан халаалтын системд зуухны гарах, эсвэл өгөх шугам дээр даралтын тэлэх сав байрлуулах. 7. Хийн болон цахилгаан зуух нь Монгол улсад мөрдеж буй хийн болон цахилгаан төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны стандартын шаардлагыг бүрэн хангасан байх; 8. Амархан гэмтэх эд ангиуд нь Монгол улсын зах зээлд олдоц сайтай байх. 9. Осол аваарын үед хий хадгалах сав болон хий дамжуулах хоолой автоматаар хаагддаг байх. Халаалт агаар сэлгэлт БНБД 41-01-11 10. Иж бүрэн камер (гадна ба дотор)-ын систем нэвтрүүлэх, алсын зайнаас хяналт хийх. 11. Хамгаалалтын бус тогтоож орчны тохижилт хийх. БНБД 3.01.06-90
9	Засвар үйлчилгээ	Барилгын тухай хуулийн 14-р зүйлийн 14.3-14.6 дахь заалт, 14.11 дэх хэсгийн заалтыг тус тус хангана.

“АЛТАН ГОВЬ ХӨГЖИЛ” ХХК

2024.09.22

№ 23/55

Улаанбаатар хот

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР-Т

Хүсэлт гаргах нь

Манай байгууллага нь Дулаан магистрал шугам угсралт засвар үйлчилгээ, даралтат зуухны угрсалт, засвар үйлчилгээ, туршилт тохироулга болон нам даралтын зуухны худалдаа, засвар үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус байгууллагаас зарласан Улсын болон орон нутгийн өмчит байгууллагын усан халаалтын зууханд техникийн шинэчлэлт хийх, дугаар БОАЖЯ/20240101067 дугаартай тендерт оролцохоор бэлдэж байна. Тус тендерийн баримт бичгийн Өгөгдлийн хүснэгтийн тусгай зөвшөөрөл хэсэгт

-ТЗ-1.3 0.1 + 5 МВт-ын хүчин чадалтай цахилгаан-дулаан хосолсон эрчим хүчиний эх үүсвэрийн угсралт, засварын ажил, түүний туршилтын тохироулгын ажил үйлчилгээ

- ТЗ-3.1 0.7-16.0 кгх/см² даралттай зуухны угсралт, засварын ажил, түүний туршилтын тохироулгын ажил үйлчилгээ гэсэн заалтууд байгаа боловч

Тендерийн өгөгдлийн хүснэгтийн 19.1-н 3 дахь хэсэгт заагдсан

Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага. “Шаардана” Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй (Хий, цахилгаан хосолсон халаалтын зуух угсралт) ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байна. гэж заажээ. Энэ нь тендерт оролцогчийн тусгай зөвшөөрлийн хүрээнд дулааны даралтат зуух, усан халаалтын зуухыг тусгай зөвшөөрлийн хүрээнд угсарч суурилуулах үйл ажиллагаа явуулдаг компани, хуулийн этгээд оролцох боломжгүй болгосон нь өрсөлдөөнийг хязгаарлахуйц нөхцөл байдлыг захиалагчийн зүгээс үүсгэсэн байна. Иймд Тендерийн 19.3 дахь хэсэгийн Тусгай зөвшөөрөл хэсэгт заагдсан

ТЗ-1.3 0.1 + 5 МВт-ын хүчин чадалтай цахилгаан-дулаан хосолсон эрчим хүчний эх үүсвэрийн угсралт, засварын ажил, түүний туршилтын тохируулгын ажил үйлчилгээ

- ТЗ-3.1 0.7-16.0 кгх/см² даралттай зуухны угсралт, засварын ажил, түүний туршилтын тохируулгын ажил үйлчилгээ гэсэн заалтуудын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлуудаас ижил төстэй ажилд тооцуулахаар болсож өөрчилж өгнө үү.

